

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2026..01.09.

Дархан-Уул аймаг

Хяналт-шинжилгээ	Бүгд	Гомдлын агуулга (чилгэлээр)						Бусад
		Боловсролын газар	Эрүүл мэндийн газар	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Сууц өмчлөгчдийн холбоо	Татварын газар	Сууц өмчлөгчдийн холбоо	
Хяналтад авсан шийдвэрийн тоо	1773	33	127	30	942	615	26	
Хэрэгжсэн	1766	33	124	30	940	615	24	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	7	-	3	-	2	-	2	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	-	-	-	-	-	-	-	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	-	-	-	-	-	-	-	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	-	-	-	-	-	-	-	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	7	-	-	-	-	-	-	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	-	-	-	-	-	-	-	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	-	-	-	-	-	-	-	
Хэрэгжих үр дүнд хүрсэн	99.14%	100%	98.92	100%	99.89	100%	96.15	

Тайлбар: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны Дугаар 183 тогтоолын хэсэрлэлт "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зур", 6.1, 6.2, 6.2.1, 6.2.2, 6.2.4, 6.3-т заасан аргачлалын дагуу биелэлтийн нэгдсэн дүнг тооцно. Хэрэгжилтийн хувь=(Хэрэгжих шаганд буй заалтын тоо*100%)/(Хэрэгжих шаганд буй заалтын тоо*50%)/Нийт заалтын тоо. Хуугаа болоогүй заалтын тоо-Хэрэгжих боломжгүй заалтын тоо.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАТЗУЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

Туу

МЭРГЭЖИЛТЭН

Г.ГЭРЭЛМАА

**ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

/2025 оны IV улирал/

2026.01.09.

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж, ажлын үр дүнг тооцох, цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэв.

Нэг: Хяналт-шинжилгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь өргөдөл, гомдлын шийдвэрийн биелэлтэд гарч буй өөрчлөлтийг тодорхой хугацаанд хэмжин, үр дүнг дүгнэж, зөв чиглүүлэхэд оршино. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны Дугаар 183 тогтоолын хавсралт “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангахад оршино.

Хоёр: Хяналт-шинжилгээний үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны Дугаар 183 тогтоолын хавсралт “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих журам”-ын дагуу нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тайлагнана.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг журмын Зургаа. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй”, 6.1, 6.2, 6.2.1, 6.2.2, 6.2.4., 6.3-т заасан аргачлалын дагуу биелэлтийн нэгдсэн дүнг тооцно.

Гурав: Хяналт-шинжилгээ хийх, арга зүй

Өргөдөл гомдлыг хүлээн авах хэлбэр:

Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл гомдлыг Засгийн газрын 11-11 төв, Нийтийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70371212 дугаарын нээлттэй утас, Дархан сумын иргэдэд үйлчлэх төвийн 70371313 нээлттэй утас, Цахимаар Вэб сайт, аппликшн, социал флатформ, мэйл гэх мэт, Аймгийн нутгийн захиргааны байгууллагад бичгээр гэх мэт бүх хэлбэрээр хүлээн авч байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдол:

Хүлээн авсан өргөдөл гомдлыг агуулгын дүн шинжилгээний хувьд авч үзэхэд нийт 8 агуулгын хүрээнд багтаж байна. Үүнээс үзэхэд нийт өргөдөл гомдлын дийлэнх буюу 35% нь НӨАТ буцаан олголт болон татварын хэлтэстэй холбоотой бол, хамгийн бага буюу 2% нь боловсрол, газрын маргаан болон бусад асуудлыг эзэлж байна.


Гомдлын агуулгын хүрээнд хийсэн хяналт-шинжилгээг, хүснэгтээр харуулбал:

Хяналт-шинжилгээ		Бүгд	Шийдвэрийн тоо	
Хяналтад авсан шийдвэрийн тоо		1773	1,2,3,4,5,6,7,8	
Үнэлгээ	Хэрэгжсэн	1766	1766	
	Хэрэгжих	Тодорхой үр дүнд хүрсэн	7	7
		Удааширалтай /эрчимжүүлэх шаардлагатай/	-	--
	Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас	-	-
		Хөрөнгө дутагдсанаас	-	-
	Хугацаа болоогүй	7	-	
	Хэрэгжих боломжгүй	-	-	
Хяналтаас хасуулах		-	-	
Хэрэгжилтийн дүн,%		100%		

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь 2025 онд нийт 1773 өргөдөл гомдол хүлээн авсан байна. Хүснэгтээр харуулбал:


№	Өргөдөл гомдол хүлээн авсан хэлбэр	Тоо	Харъяалал		Эзлэх хувь
1	Засгийн газрын 11-11 мэдээллийн төв	228	АЗДТГ	228	12.9
2	Биеэр	505	Аймгийн ЗДТГ	9	28,5
			Дархан сум	283	
			Шарын гол сум	2	
			Боловсролын газар	22	
			ГХБХГ	30	
			ЗАА	52	
			НДГ	4	
			ХААГ	1	
			СХЗХ	1	
			Татварын хэлтэс	1	
ЭМГ	100				
3	Бүртгэлийн нэгдсэн лавлах 70371212, 70371313	198	АЗДТГ		11.2
		Дархан сум	123		
		ЭМГ	25		
4	Албан бичиг	127	Дархан сум	124	7.2
		Боловсролын газар	3		
5	Цахим	715	Дархан сум	91	40.3
			БГ	8	
			Татварын хэлтэс	614	
			ЭМГ	2	
Нийт		1773			100

Өргөдөл гомдлын төрлийг харуулбал:




Нийт өргөдөл гомдлын 457 буюу 25.78 хувийг *мэдэгдэл*, 744 буюу 42 хувийг *гомдол*, 521 буюу 29.4 хувийг *санал*, 51 буюу 2.9 хувийг *хүсэлт* эзэлж байна.

Ирсэн өргөдөл гомдлыг холбогдох байгууллагаар нь харуулбал:



Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн 1773 өргөдөл, гомдлын 35.03 хувь Дархан суманд, 34.69 хувь Татварын хэлтэст, 16.2 хувь нь АЗДТГ-т, 7.2 хувь нь Эрүүл мэндийн газарт, үлдсэн хувь нь бусад газарт ирүүлсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ирсэн өргөдөл гомдол **15.35** хувиар өссөн байна. Төрлөөр нь харуулбал, гомдол 468 буюу 62.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Шийдвэрлэлт:

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 6 агуулгын хүрээнд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн шинжилгээ 100 хувьтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хяналт-шинжилгээ	Бүгд	Гомдлын агуулга							
		БГ	Эрүүл мэндийн газар	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Сууц өмчлөгчдийн холбоо	Татварын газар	Бусад		
Хяналтад авсан шийдвэрийн тоо	1773	33	127	30	942	615	26		
Үнэлгээ	Хэрэгжсэн	1766	33	124	30	940	615	24	
	Хэрэгжих шатанд	Тодорхой үр дүнд хүрсэн	7	-	3	-	2	-	2
		Удааширалтай /эрчимжүүлэх шаардлагатай/	-	-	-	-	-	-	-
	Хэрэгж эгүй	Зохион байгуулалтаас	-	-	-	-	-	-	-
		Хөрөнгө дутагдсанаас	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	7	-	-	-	-	-	-	
	Хэрэгжих боломжгүй	-	-	-	-	-	-	-	
Хяналтаас хасуулах	-	-	-	-	-	-	-		
Хэрэгжилтийн дүн, %	99.14%	100%	98.82	100%	99.89	100%	96.15		

Агуулгын хүрээнд ангилж үзэхэд нийт ирсэн өргөдөл гомдлын 53.13 хувь нь сууц өмчлөгчдийн холбоотой нутгийн захиргааны байгууллагад хандсан байна.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дүнг өмнөх онтой харьцуулбал:



Шийдвэрлээгүй 7 өргөдөл, гомдол нь хугацаа болоогүй хяналтад авсан байна.

Дөрөв: Дүгнэлт:

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 1773 өргөдөл, гомдол ирүүлснээс 1766 өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэж, 7 өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн шатандаа байна. Ирсэн талархал байхгүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хийсэн хяналт шинжилгээний дүн 99.14 хувьтай байна. Өргөдөл гомдлын мэдээ улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

Өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 01-A/226 дугаар захирамжаар батлагдсан журам болон бусад ууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.35 хувиар өссөн үзүүлэлтийн гол шалтгаан нь:

1. Хүн ам, суурьшлын өөрчлөлт

- Дархан хотын хүн амын өсөлт, хөдөө орон нутгаас шилжин суурьшигчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор төрийн үйлчилгээний ачаалал өссөн.

- Шинээр суурьшсан иргэд газар, орон сууц, бүртгэл, нийгмийн үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол түлхүү гаргах болсон.

2. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл

- Инфляц, өрхийн орлогын бодит бууралт, ажил эрхлэлтийн тогтворгүй байдал нь нийгмийн халамж, тэтгэмж, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг нэмэгдүүлсэн.
- Орон сууц, түрээсийн үнэ өссөнөөс шалтгаалж байр, дэд бүтэц, ашиглалттай холбоотой өргөдөл, гомдол нэмэгдсэн.

3. Дэд бүтэц, нийтийн аж ахуйн асуудал

- Дулаан, ус хангамж, цахилгаан тасалдал, авто замын эвдрэл, тохижилттой холбоотой гомдол улирлын чанартайгаар өссөн.

4. Иргэдийн эрх зүйн мэдлэг, идэвх нэмэгдсэн байдал

- Иргэд төрийн байгууллагад хандах, санал гомдлоо илэрхийлэх эрх зүйн мэдлэг сайжирч, асуудлаа албан ёсоор тавих идэвх нэмэгдсэн.
- Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв, цахим өргөдөл, гомдлын системийн хүртээмж сайжирснаар өргөдөл гаргах боломж хялбар болсон.

5. Цахимжилт, хүлээн авах сувгийн өөрчлөлт

- Цахимаар болон 11-11 төвөөр дамжуулан ирэх өргөдөл, гомдлын тоо өссөн нь нийт тоо нэмэгдэхэд нөлөөлсөн (давхардалгүй бүртгэл сайжирсан).

2025 онд Дархан-Уул аймгийн хэмжээнд өргөдөл, гомдлын тоо өссөн бөгөөд энэ нь нэг талаас тулгамдсан асуудлууд байгааг, нөгөө талаас иргэдийн оролцоо, эрхээ хамгаалах идэвх нэмэгдсэнийг илэрхийлж байна. Цаашид өргөдөл, гомдлын шалтгаанд суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

Тав: Зөвлөмж


1. Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын 2025 оны 11 сарын 19-ний өдрийн А/66 дугаар тушаалын хавсралт “Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам” 1,2,3, дугаар хавсралтын дагуу гаргаж ирүүлэх.
2. **Бодлогын түвшинд:** Өргөдөл, гомдлыг бүртгэх, ангилах, урьдчилан сэргийлэх бодлогыг эрчимжүүлэн, мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчлах.

- 3. **Удирдлагын түвшинд:** Өргөдөл, гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, түргэн шуурхай хүнд сурталгүй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах
- 4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт бүрд нотлох баримт цуглуулах, шалтгаан нөхцлийг тодруулж тайландаа тусгах.

Санал: 1. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлын хүрээнд сэтгэл ханамжийн судалгаа зохион байгуулах.

ХЯНАГАН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 ХЭЛТСИЙН ДАРГА  Б.БАТЗУЛ



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН  Г.ГЭРЭЛМАА